



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№90 /303/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2022.05.10

Цаг үе, үйл явдал

МОНГОЛ БИЧГИЙН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО

Батлан хамгаалахын сайдын тушаалаар Монголын ард түмний оюуны соёлын нандин өв болсон монгол бичгээ хадгалан хамгаалж, сурч эзэмших, түгээн дэлгэрүүлэх идэвхийг өрнүүлэх, бүх нийтийг сургах, монгол бичгийн хэрэглэх орчныг бий болгох зорилгоор монгол бичгийн уралдааныг Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний офицер ахлагч, ажилтан алба хаагч багш, судлаач, оюутан сонсогч, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дунд зохион байгуулан шилдгүүдэд тодрууллаа.

Тус уралдаан нийт таван төрлөөр явагдсан бөгөөд уран бичлэгийн төрөлд тэргүүн байрыг Зэвсэгт хүчний 340 дүгээр ангийн соёл хүмүүжлийн офицер ахлах дэслэгч Б.Долгосүрэн, дэд байрыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн суртал нэвтрүүлэгч ахмад Д.Мөнх-Өнөр, гутгаар байрыг УБХИС-ийн оюутан Д.Энхтулга, компьютерт эх бичвэрийг монгол бичгээр шивэх төрөлд тэргүүн байрыг Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн суртал нэвтрүүлэгч ахмад Д.Мөнх-Өнөр, дэд байрыг Зэвсэгт хүчний 339

дүгээр ангийн хэрэг хөтөлгөч ахлах ахлагч Д.Уянга, гутгаар байрыг Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн нярав ахлах ахлагч Ю.Мөнхөө, таталган бичгийг алдаагүй зөв унших төрөлд тэргүүн байрыг Батлан хамгаалахын Төв архивын нууцын дарга, дэд ахлагч Б.Бямбаа, дэд байрыг Батлан хамгаалахын Төв архивын сэлбэн засагч-оператор О.Золбоо, гутгаар байрыг Батлан хамгаалахын Төв архивын сан хөмрөгийн албаны дарга, сан хөмрөгийн эрхлэгч хошууч Б.Тогтохжаргал, алдаагүй зөв бичих төрөлд тэргүүн байрыг Хөгжмийн коллежийн тэнхимийн ахлах багш ахлах дэслэгч Г.Батдорж, дэд байрыг Кибер аюулгүй цэргийн командлалын нууцын дарга сургагч ахлагч Г.Энхжаргал, гутгаар байрыг Цэргийн төв эмнэлгийн эмчдэслэгч Д.Мөнхцацрал, цэвэр сайхан бичих төрөлд тэргүүн байрыг УБХИС-ийн оюутан С.Өлзийхишиг, дэд байрыг УБХИС-ийн оюутан Г.Түмэнжаргал, гутгаар байрт УБХИС-ийн оюутан О.Отгонсүрэн нар тус тус эзэлжээ.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 2	☁️ -9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	☁️ 26

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,105.00	3,115.0
EUR 🇪🇺	3,320.0	3,350.0
CNY 🇨🇳	468.00	471.00
RUB 🇷🇺	41.00	42.00
JPY 🇯🇵	24.00	24.60
KRW 🇰🇷	2.46	2.49

ЗУРХАЙ



НЭГ ЭНХИЙГ САХИУЛАГЧ-НЭГ МОД



“Тэрбум мод” үндэсний хөтөлбөр, Монгол цэрэг энхийг үйлсэд оролцож эхэлсний 20 жилийн ойг тохиолдуулан “Монгол цэрэг-Энхийн төлөө” дурсгалын цогцолбор хөшөөний ойр орчмыг моджуулах үүднээс нэг энхийг сахиулагч нэг мод арга хэмжээг өнөөдөр зохион байгууллаа. Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, орлогч дарга бригадын генерал Ц.Цогтжаргал, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат, ШШГЕГ-ын тэргүүн дэд дарга бригадын генерал Д.Дамдинцэрэн болон төрлийн цэргийн командлал болон Барилга-Инженерийн удирдах газрын төлөөлөл, тэргүүн ахлагчид, энхийг сахиулагчдын төлөөлөл оролцлоо.

Нэг энхийг сахиулагч нэг мод арга хэмжээний хүрээнд гацуур, улиас, монос зэрэг 3 төрлийн 300 орчим модны суулгацыг тарилаа. Цаашид “Монгол цэрэг-Энхийн төлөө” дурсгалт цогцолбор

хөшөөний орчмыг битүү моджуулахаас гадна хүүхдийн тоглоомын газар, иргэд олон нийтийн чөлөөт цагийн зөв боловсон өнгөрөөх чийрэгжүүлэх, бялдаржуулах орчмыг бий болгох тохижилтын ажлуудыг хийх юм.

Сонирхуулахад, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн хувьд Маршалын гүүрнээс Улиастайн гүүр хүртэл нийт 973 га талбайд оршдог бөгөөд 183 га талбайг тохижуулсан бөгөөд одоогийн байдлаар тус талбайн 85 хувьд ногоон байгууламж бий болгох, мод тарих ажлыг хийж байгаа юм. Тус байгууллагын тарьж, ургуулсан 150 мянга гаруй мод 98.5 хувийн амьдралтайгаар ургаж байгаа албаныхан энэ үеэр онцолж байв. Тиймээс энэхүү Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ногоон байгууламжийн ажилд манай энхийг сахиулагчид ийнхүү гар бие оролцон мод тарих ажилд идэвхтэй хамрагдсаар байх юм.

ЗУНЫ ТЭРГҮҮН ХӨХӨГЧИН МОГОЙ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Үс засуулбал:
Өвчин өчүүхэн ирнэ
Наран ургах, шингэх:
Нас уртасна
Барилдлага:
Арвидах
Шүтэн барилдлага:
Мунхрахуй
Суудал: Хий

Энэ өдөр хонь, туулай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр худалдаа арилжаа хийх, бизнэс эхлэх, хүү сангийн эх хатгах, эд агуурс авах, зээл авах, арвижуулах, дэлгэрүүлэх үйлийг эхлэх, сан тавиулах, угаал үйлдэх, нялхсын хурим хийх, огторгийн үүдийг боох, их хүмүүнтэй уулзахад сайн. Газар ухах, худаг гаргах, сэтгэлд сөвтэй газар очих, балгадын суурь тавих, нохой худалдан авахад муу.

Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагшаа мөрөө гаргавал зохистой. Дашнямтай өдөр. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСЫН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,273,004 /69.9%!	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,175,662 /66.9%!	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,040,412 32,0% 125,447 /3,9%!
НИЙТ БАТЛАГДСАН 8488 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 24	ЭДГЭРСЭН 8343

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол Нийт: 517,260,241
Эдгэрсэн Нийт: 471,936,537
Нас барсан Нийт: 6,276,465

ИРГЭН ТА ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛАА ХЭРХЭН ТӨЛӨХ БЭ?

- ✓ ДАМАГ, ДҮГҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС
- ✓ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН ТӨВ (Дүнжингарал, Мишээл эхэс, Драгон, Банкшоу, Инарт 3,4 хороолол)
- ✓ БҮХ ТӨРЛИЙН ИНТЕРНЕТ БАНК
- ✓ ЭНДЕГ-ЫН ГАР УТАСНЫ EDAATGAL АППЛЕЙШН
- ✓ И-БАРИМТААР ТУС ТУС ТӨЛӨХ БОЛОМЖТОЙ.

ЭМД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХЭЛТЭС

Лавлах утас: 1800-1363

Эрүүлмүүлэг /Урьдчилан-Сэрвэлээ/Газар

Цахим шууданд

САЙН ҮЙЛСИЙН АЯНД НЭГДЛЭЭ



Тус аянд Зэвсэгт хүчний 325 дугаар анги Завхан аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас энэ оны 4 дугаар сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 06-ны өдрийг дуустал байнгын асаргаанд байдаг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд туслах зорилгоор "Эргэх холбоо хамтын хүч" аяныг өрнүүлээд байна.

Тус аянд Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн бие бүрэлдэхүүн нэгдэж, гурил, будаа, гоймон болон бусад өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүнээр тусламж үзүүлээ. Бусдын төлөө хийсэн сайн үйлс бүхэн тань буян болон хурж будаа мэт арвижих болтугай.

Ахмад
Н.МӨНХБААТАР

Фото мэдээ

“Тэрбум мод” Үндэсний хөтөлбөрт Батлан хамгаалах салбарын оролцоо

НЭГ ЭНХИЙГ САХИУЛАГЧ-НЭГ МОД



ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙГЭЭС ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



ОЛОН УЛСЫН МУЗЕЙН ӨДРИЙГ ТОХИОЛДУУЛАН МОНГОЛ ЦЭРГИЙН МУЗЕЙГЭЭС ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

INTERNATIONAL MUSEUM DAY
The Power of Museums

ICOM
ICOM PRAGUE 2022



ЗОРИЛГО: Олон Улсын музейн зөвлөлөөс гаргасан "МУЗЕЙН ХҮЧ НӨЛӨӨ" уриан дор музейгээс иргэдэд чиглэсэн соёлын үйлчилгээг сайжруулж музейн тэгш хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэн, музейн дотоодод чиглэсэн үйл ажиллагааг идэвхжүүлж, музейн ажлыг олон нийтэд танилцуулахад оршино.

- ЗОРИЛТ:**
- Цахимжуулалт ба хүртээмжийг шинэчлэх
 - Тогтвортой байдлыг бий болгох
 - Боловсролоор дамжуулан хүн амыг нэгтгэх гэсэн зорилтын хүрээнд дараах цогц ажил арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ

ХУГАЦАА:
2022.04.20
2022.05.18

ЦАХИМЖУУЛАЛТ БА ХҮРТЭЭМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- Нээлттэй зурагт самбар ажиллуулах- Музей үзээд төрсөн сэтгэгдэл, санал, хүсэлт, шүүмжээ бичиж үлдээх зурагт самбар ажиллуулах, Үзэгчдийн сэтгэгдэлийг сонсож үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлнэ.
- Цахим сурталчилгаа- Монгол цэргийн музейн албан ёсны цахим хаяг болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан Олон Улсын музейн өдөрт зориулан хийгдэх үйл ажиллагааг олон нийтэд сурталчилна.
- Дүрс бичлэг /Шторк/- Музейн үйл ажиллагааг танилцуулсан бичлэг хийж олон нийтэд сурталчилна.
- Нээлттэй хаалга- Олон улсын музейн өдрөөр иргэдэд үнэ төлбөргүй үйлчилнэ.

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ БИЙ БОЛГОХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- "МУЗЕЙН ХҮЧ НӨЛӨӨ-ЦЭРГИЙН АЛБАНД" танин мэдэхүйн аялал
Оролцох бүрэлдэхүүн: Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг музейн ажилтан, албан хаагчдын төлөөлөл
ХААНА: Зэвсэгт хүчний 015 дугаар ангид
ХУГАЦАА: 05 дугаар сарын 04
- "МАНЛАЙЛАЛ БА МАРКЕТИНГ" сургалт Мастер маркетинг төвийн багш С.Жавхлан
Оролцох бүрэлдэхүүн: Монгол цэргийн музейн ажилтан, албан хаагчид
ХААНА: Монгол цэргийн музейд
ХУГАЦАА: 05 дугаар сарын 16

БОЛОВСРОЛООР ДАМЖУУЛАН ОРОН НУТГИЙН ХҮН АМЫГ НЭГТГЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

- Боловсролын ажил- "Музей нүүж явна" хөтөлбөрийн хүрээнд цуврал сургалт, боловсролыг ажлыг зохион байгуулна.
Оролцох бүрэлдэхүүн: Баянзүрх дүүргийн 53 дугаар дунд сургууль ахлах ангийн сурагчид, Налайх дүүргийн 117 дугаар сургуулийн 9 дүгээр сурагчид
- Нүүдлийн үзэсгэлэн- "МОНГОЛ ЦЭРГИЙН ТҮҮХЭН ЗАМНАЛ"
ХААНА: Дорноговь аймгийн Сайншанд хотын Хүүхдийн ордон
ХЭЗЭЭ: 05 дугаар сарын 12-14 өдрүүдэд



Олон улсын музейн зөвлөлөөс (ICOM) 1977 онд нийгмийн хөгжилд музейн гүйцэтгэх үүргийг олон нийтэд илүү их өргөн таниулах үүднээс Олон улсын музейн өдрийг жил бүрийн 5 дугаар сарын 18-ны өдөр тэмдэглэж байхаар тогтсон. Тус өдрийг жил бүр өөр өөр уриан дор тэмдэглэн өнгөрүүлдэг бөгөөд 2022 онд "МУЗЕЙН ХҮЧ НӨЛӨӨ" сэдвийн хүрээнд Монгол цэргийн музей дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2022 ОНЫ ӨСВӨР ҮЕИЙН УАШТ ЯВАГДЛАА



Жүдо бөхийн 2022 оны Монгол Улсын Өсвөр үеийн аварга шалгаруулах эрэгтэйчүүдийн 35, эмэгтэйчүүдийн 26 дахь удаагийн тэмцээнд Монгол орны өнцөг булан бүрээс цугласан 1300 гаруй

хүүхдүүд гурван насны ангилалд хүч чадал, ур чадвар, авхаалж самбаагаа сорин өрсөлдөн, 5 дугаар сарын 5-6-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо амжилттай явагдаж өндөрлөлөө. Энэ тэмцээнд Зэвсэгт хүчний Алдар спорт хорооны Д.Батсайхан дасгалжуулагчтай өсвөр үеийн баг тамирчид 1 алт, 1 хүрэл медаль хүртлээ. Мөн Алдар спорт хорооны тамирчин А.Энхбаяр тус тэмцээний "ШИЛДЭГ ТАМИРЧИН"-аар шалгарлаа. Үүнд, - 90 кг-ийн жинд А.Энхбаяр алтан медаль, - 48 кг-ийн жинд Б.Гүндэгмаа хүрэл медаль тус тус хүртлээ.



Дарга, ерөнхий редактор, хурандаа
САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ

ЦАХИМ ХАЯГ
Батлан хамгаалах яам
Зэвсэгт хүчний Жанжин штаб

ЦАХИМ ХУУДАС
"Соёмбо" сонин
"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонины мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Оффисеруудын ордон
Индекс: 10018
Цахим шуудан:
Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029, 3412 (дотуур)